



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/9/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Ankhubayard@audit.gov.mn">Ankhubayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:ganbaatarz@audit.gov.mn">ganbaatarz@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 40.

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
М.БАТЖАРГАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн ИТХ-н 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн ИТХ-н 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020104

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>49,298,550.60</b>	<b>42,849,920.60</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	49,298,550.60	42,849,920.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,298,550.60	42,849,920.60
35410	Бичиг хэргийн материал	10,906,990.00	12,436,900.00
35420	Аж ахуйн материал	23,426,927.60	17,626,777.60
35430	Сэлбэг хэрэгсэл	350,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	14,614,633.00	12,786,243.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>85,904,631.05</b>	<b>191,316,589.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	85,904,631.05	191,316,589.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	85,686,922.65	191,144,714.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,205,610.00	21,205,610.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,843,966.08	-2,765,949.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	220,500,000.00	108,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-211,500,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,094,775.00	95,478,475.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,748,100.36	-50,337,821.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,624,856.00	55,674,856.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,646,251.91	-36,110,455.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	217,708.40	171,875.12
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-57,291.60	-103,124.88
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>135,203,181.65</b>	<b>234,166,510.13</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>135,203,181.65</b>	<b>234,166,510.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	135,203,181.65	234,166,510.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	129,555,712.65	129,555,712.65
51102	- хувийн	129,555,712.65	129,555,712.65
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,647,469.00	104,610,797.48
51210	Өмнөх үеийн үр дүн	5,647,469.00	5,647,469.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	98,963,328.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>135,203,181.65</b>	<b>234,166,510.13</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,615,651,300.00</b>	<b>925,545,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,043,000.00</b>	<b>108,591,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,043,000.00	108,591,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,043,000.00	108,591,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,043,000.00	108,591,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,614,608,300.00</b>	<b>816,954,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,080,176,000.00	135,203,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,080,000,000.00	135,203,500.00

**Аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	176,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>534,432,300.00</b>	<b>681,750,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,432,300.00	681,750,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,639,357,485.45</b>	<b>826,582,071.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,639,357,485.45</b>	<b>826,582,071.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>406,967,451.23</b>	<b>483,092,392.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>182,656,519.00</b>	<b>194,951,526.26</b>
210101	Үндсэн цалин	128,942,682.00	140,514,127.26
210102	Нэмэгдэл	49,913,337.00	38,877,490.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,800,500.00	4,134,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,425,909.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,804,319.78</b>	<b>25,324,663.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,506,935.14	17,526,605.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,824,344.66	1,949,515.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,459,479.93	1,559,612.18
210204	Ажилгүйдлийн даатгал	364,870.73	389,903.13
210205	Эрүүл мэндийн даатгал	3,648,689.32	3,899,027.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,348,937.00</b>	<b>20,123,839.00</b>
210401	Бичиг хэрэг	2,072,300.00	2,291,790.00
210402	Тээвэр, шатахуун	15,850,620.00	15,309,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,205,557.00	1,576,849.00
210404	Ном, хэвлэл	220,460.00	64,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	881,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>210,000.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,464,000.00</b>	<b>35,626,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,495,000.00
210604	Урсгал засвар	4,464,000.00	34,131,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,951,400.00</b>	<b>2,867,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,951,400.00	2,867,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,972,758.00</b>	<b>3,042,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,884,998.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,679,660.00	2,743,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,100.00	255,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>168,559,517.45</b>	<b>201,156,588.32</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,127,544.00	115,519,046.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,002,585.00	54,615,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,429,388.45	31,021,741.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,232,390,034.22</b>	<b>343,489,679.25</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>8,250,000.00</b>	<b>00.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,250,000.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,187,595,238.00</b>	<b>301,865,639.29</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,339,844.00	130,089,166.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,851,473.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,091,255,394.00	131,925,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>36,544,796.22</b>	<b>41,624,039.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,544,796.22	41,624,039.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-23,706,185.45</b>	<b>98,963,328.48</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-23,706,185.45</b>	<b>98,963,328.48</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,555,712.65	632,005.78	28,721,648.67	158,909,367.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	632,005.78	632,005.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,555,712.65	632,005.78	29,353,654.45	159,541,372.88
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-23,706,185.45	-23,706,185.45
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,555,712.65	00.00	5,647,469.00	135,203,181.65
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,555,712.65	00.00	5,647,469.00	135,203,181.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,555,712.65	00.00	5,647,469.00	135,203,181.65
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	98,963,328.48	98,963,328.48
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,555,712.65	00.00	104,610,797.48	234,166,510.13

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,614,608,300.00	816,954,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,614,608,300.00	816,954,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,080,176,000.00	135,203,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,080,000,000.00	135,203,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	176,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	534,432,300.00	681,750,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,432,300.00	681,750,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,602,618,900.00	788,520,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,602,618,900.00	788,520,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,609,015.78	446,944,520.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,656,519.00	194,951,526.26
210101	Үндсэн цалин	128,942,682.00	140,514,127.26
210102	Нэмэгдэл	49,913,337.00	38,877,490.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,800,500.00	4,134,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,425,909.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,804,319.78	25,324,663.69
210201	Тэтгэврийн даатгал	15,506,935.14	17,526,605.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,824,344.66	1,949,515.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,459,479.93	1,559,612.18
210204	Ажилгүйдлийн даатгал	364,870.73	389,903.13
210205	Эрүүл мэндийн даатгал	3,648,689.32	3,899,027.57
2104	Хангамж, бараа материалын зардал	16,545,165.00	18,904,049.00
210401	Бичиг хэрэг	1,177,148.00	1,324,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,942,000.00	14,942,000.00

**Аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,205,557.00	1,576,849.00
210404	Ном, хэвлэл	220,460.00	64,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	996,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	210,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,364,000.00	34,934,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,495,000.00
210604	Урсгал засвар	4,364,000.00	33,439,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,951,400.00	2,867,000.00
210702	Дотоод албан томилолт	2,951,400.00	2,867,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,087,258.00	3,042,175.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,999,498.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,679,660.00	2,743,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,100.00	255,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	121,990,354.00	166,920,506.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,559,054.00	107,275,896.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,431,300.00	59,644,610.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,246,009,884.22</b>	<b>341,576,179.25</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	8,250,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,250,000.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,201,215,088.00	299,952,139.29
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	109,959,694.00	128,175,666.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,851,473.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,091,255,394.00	131,925,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	36,544,796.22	41,624,039.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,544,796.22	41,624,039.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,989,400.00</b>	<b>28,433,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,989,400.00</b>	<b>28,433,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,989,400.00</b>	<b>28,433,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,989,400.00	28,433,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,989,400.00	28,433,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-11,989,400.00</b>	<b>-28,433,700.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0	0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	711,750,900.00	681,750,900.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	711,750,900.00	681,750,900.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	526,545,700.00	461,174,720.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,422,400.00	194,951,526.26
210101	Үндсэн цалин	136,754,200.00	140,514,127.26
210102	Нэмэгдэл	70,868,200.00	38,877,490.00

**Аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,680,000.00	4,134,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,120,000.00	11,425,909.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,702,000.00</b>	<b>25,324,663.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,605,200.00	17,526,605.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,274,200.00	1,949,515.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,819,400.00	1,559,612.18
210204	Ажилгүйдлийн даатгал	454,800.00	389,903.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,548,400.00	3,899,027.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,102,000.00</b>	<b>18,904,049.00</b>
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,324,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	14,942,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,602,000.00	1,576,849.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	64,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	996,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>61,010,800.00</b>	<b>60,448,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,520,000.00	25,958,900.00
210602	Тавилга	1,050,000.00	1,050,000.00
210604	Урсгал засвар	33,440,800.00	33,439,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,500,000.00</b>	<b>2,867,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	10,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,500,000.00	2,867,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,376,500.00</b>	<b>3,042,175.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	2,743,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	532,500.00	255,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>167,432,000.00</b>	<b>155,636,806.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,432,000.00	100,392,296.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,000,000.00	55,244,510.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>185,205,200.00</b>	<b>178,952,139.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>185,205,200.00</b>	<b>178,952,139.29</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	134,153,700.00	128,175,666.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,851,500.00	39,851,473.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,200,000.00	10,925,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>711,750,900.00</b>	<b>681,750,900.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>711,750,900.00</b>	<b>681,750,900.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	711,750,900.00	681,750,900.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>135,203,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>135,203,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>14,203,500.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	14203500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7,403,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	121000000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		121,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		121,000,000.00

IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 02/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны үйл ажиллагаандаа дотоод хяналтын 9 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол шийдвэрт хяналт тавих
2. Сумын ИТХ-ын Хуралдааны материалудтай танилцах
3. Сумдын ИТХ-ын дотоод ажилд хяналт тавих
4. Шилэн дансны хуулийн дагуу тогтоол шийдвэр, мэдээллийг хугацаандаа тавьсан эсэхэд хяналт тавих
5. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих
6. Hural.mn сайтад баяжилт, мэдээллийн самбарт мэдээллийг хугацаандаа тавьж байгаа эсэхийг нягтлах
7. Мэдээллийн технологийн аюулгүй байдалд хяналт тавих
8. Автомашины бүрэн бүтэн байдалд, техник ашиглалтад хяналт тавих
9. Байгууллагын хөрөнгийн тооллого хийх гэсэн нийт 9 арга хэмжээг хэрэгжүүлж 100 хувийн биелэлттэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 1,639.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант тайлант онд тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийг үнэлсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/төгрөгөөр /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	49,298,550.60	42,849,920.60	-6,448,630.00
Үндсэн хөрөнгө	85,904,631.05	191,316,589.53	105,411,958.48
Нийт хөрөнгө	135,203,181.65	234,166,510.13	98,963,328.48
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	135,203,181.65	234,166,510.13	98963,328.48
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	135,203,181.65	234,166,510.13	98,963,328.48

**Авлага:** Тайлант онд 0 төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

**Бараа материал:** Бараа материалын дансны үлдэгдэл 42,849.9 мянган төгрөг болж 6,448.6 мянган төгрөгөөр буурсан нь нөөц бараа материалаа зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2012-2021 онд худалдаж авсан аймгийн ИТХ-ын нэрэмжит шагналууд, шийдвэрийн эмхэтгэл, танилцуулга, түүхийн зураг 30,063.7 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн бараа материал байна.

Энэ нь тайланд онд бараа материалын үлдэгдэл ихтэй харагддаг байна. Оны эцэст 9,200.0 мянган төгрөгийн шатахууны талоны худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь материалын үлдэгдэл их өмч хөрөнгийн дүн өндөр байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 191316,6 мянган төгрөг болж 98963,3 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тээврийн хэрэгслийн үнийг шинэчлэн тогтоож үнэлсэн, 28,433.7 мянган төгрөг тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалжээ.

**Өр төлбөр:** Тайлант онд 0 төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 836.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 836.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 125.2 сая төгрөгөөр бууруулан 711.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 711.7 сая төгрөгийн төсөв баталснаас 711.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0 үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 681.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 0 бусад орлого 0 сая төгрөг нийт 0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 640.1 сая төгрөгийг зарцуулж 41.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос 121.0 сая төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 7.4 сая төгрөг, Төлөөллийн байгууллагыг хэрэгжүүлэх төслийн нэгжээс 6.8 сая төгрөг нийт 135.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цагаатгалын нөхөх олговорт 121.0 сая төгрөг, төслийн сургалтын зардалд 6.8 сая төгрөг, хамтарсан багийн санхүүжилтэнд 6.9 сая, зохицуулах зөвлөлийн сургалтын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд 1,050.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авчээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7, 6.4.8, 6.10 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ 6.4.7-д “байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;”, 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитаар байгууллагад шилэн дансны мэдээллийг хуульд зааснаар хэрэгжүүлж байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,050.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 1,050.0 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 2 албан шаардлага өгч ажиллаа.

##### 4.1 Албан шаардлага

Тайлант онд 1,050,000.0 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

##### 4.2 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7, 6.4.8, 6.10 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ИТХ	2	1.0					2	1.0		
	Нийт дүн	2	1.0					2	1.0		

/сая төгрөгөөр/